

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН ТУЛГУУРТ ГАДААД БОДЛОГО БА МОНГОЛ- ОРОСЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Д. Батжаргал<sup>1</sup>*

***Товч агуулга:** Монгол Улсаас умард хөрш ОХУ-тай харилцах боловсролын салбарын хамтын ажиллагаа бол Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого дахь тэнцвэрт байдлыг хангах нэг хүчин зүйл юм. Сүүлийн жилүүдэд гадаадад сурдаг нийт монгол оюутны тоонд Орост сурдаг монгол оюутны эзлэх хувь багасч, ирээдүйд орост сурсан боловсон хүчин огцом буурах хандлагатай болжээ.*

***Abstract:** The relationship of Russia and Mongolia which is established to our north neighbor country is our main pillar of Mongolian multilateral foreign policy. In this article talks that since last years are decreasing the amount of Mongolian students in Russia to compare total amount of Mongolian students in foreign countries. Perhaps it would be impacted a Mongolian multilateral foreign policy.*

***Түлхүүр үг.** Гэрээ хэлэлцээр, боловсролын гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаа, оюутан солилцоо.*

Аливаа улсын гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь дараах хоёр зүйлээр тодорхойлогддог. Нэгдүгээрт, аль ч улс орон бусад улс, ард түмэнтэй, ялангуяа хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа олон талын харилцаатай байдаг. Хоёрдугаарт, аль ч улс орон зөвхөн төрийн дотоод бодлогын үр дүн нийгмийн бүхий л хэрэгцээг хангаж чаддаггүй. Энэ нь мөн л гадаад орчинтой харилцаж байж зарим хэрэгцээгээ хангах үйл ажиллагааг шаарддаг. Уг үйл

---

<sup>1</sup> Батжаргал Д., БНХАУ-ын Жилинь их сургуулийн докторант (中国吉林大学国际政治博士生).

ажиллагааг тодорхой бодлого болгон явуулахгүйгээр зохих үр дүнд хүрдэггүй.

1990-ээд оны эхээр Монгол Улсад гарсан улс төр, нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн үр дүнд бие даасан гадаад бодлого явуулах болсоноор гадаад харилцааны хүчин зүйлийг оновчтой, бүрэн ашиглах зүй ёсны шаардлага гарсан юм. Дэлхийн улс төрийн бодлого, олон улсын харилцаанд зарчмын өөрчлөлтүүд гарсан нь Монгол Улсын гадаад бодлогын үйл ажиллагаанд ч таатай нөхцлийг бүрдүүлсэн. Тухайлбал, соёлын харилцаа нь улс төрийн гадаад бодлого, зорилтыг хэрэгжүүлэх чухал суваг болж тогтвортой хөгжиж байгаа бөгөөд боловсрол, шинжлэх ухаан, мэдээлэл, спорт, хүмүүнлэгийн салбарыг хамарсан өргөн цар хүрээтэй баялаг агуулгатай явж ирэв. Тухайлбал, МУ-ын Их хурлаас 2011 онд шинэчлэн баталсан Гадаад Бодлогын үзэл баримтлалын V дугаар зүйл соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын 25 дугаар зүйлд “Соёл, хүмүүнлэгийн салбарын гадаад бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ гээд: 1 дүгээрт “Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулан сайжруулах”, 2 дугаарт “Үндэсний хөгжилд нэн шаардагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, 3 дугаарт, “Боловсрол, соёл, урлаг зэрэг олон улсын байгууллагатай идэвхитэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, байгууллага хоорондын солилцоог хөгжүүлэх арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ” хэмээн заажээ<sup>2</sup>. 2011 оны гадаад бодлогын үзэл баримтлал нь соёл, боловсролын салбарын үйл ажиллагааны гол зорилго, зорилтыг үе үеийн үзэл баримтлалын гол суурь, тэргүүлэх чиглэлд тусгаж өгсөн нь Монгол Улс дээр дурьдсан салбаруудад, нэн ялангуяа боловсролын салбарт баримтлах гадаад бодлогын жанжин шугам нь өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй залгамж, нэгдсэн чанараа хадгалж нэг санаа, нэгдмэл байр суурьтайгаар, шат дараатайгаар хэрэгжүүлэхээр заагдсан нь харагдаж байна.<sup>3</sup>

2 Гадаад Харилцааны Яам сайт, <http://www.mfa.gov.mn/index.php>

3 Бүдсүрэн,Д., “Монгол-АНУ-ын боловсролын салбарын хамтын ажиллагаанд олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг: Фулбрайт болон Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөрийн жишээн дээр”, Гах

*Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого ба Монгол-Оросын боловсролын салбарын хамтын ажиллагаа*

Монгол Улс боловсролын салбарын гадаад бодлогын хүрээнд өнгөрсөн 26 жилийн хугацаанд Орос, Хятад, Польш, Унгар, Энэтхэг, Австри, Турк, Солонгос зэрэг 14 улс оронтой Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр байгуулж, нийт 70 мянга орчим оюутан сургасны 70 орчим хувь нь БНХАУ, ОХУ, БНСУ, Япон болон АНУ-д суралцаж байна. Эдгээр орнуудын дотор хамгийн их тэтгэлэг олгодог оронд ОХУ, БНХАУ орж байна.

**2006-2016 онд хоёр орны Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын их, дээд сургуульд элссэн бакалавр, магистрант, докторантын тоо**

| Улс       | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|-----------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| ОХУ       | 200  | 200  | 220  | 230  | 232  | 298  | 208  | 220  | 226  | 350  | 474  |
| БНХАУ     | 152  | 168  | 220  | 200  | 253  | 315  | 319  | 355  | 353  | 376  | 361  |
| Унгар     | 5    | 6    | 6    | 5    | 5    | 5    | 4    | 5    | 15   | 79   | 98   |
| Украин    | 8    | 7    | 2    | 5    | 3    | 3    | 22   | 20   | 10   | 8    | 9    |
| Польш     | 11   | 22   | 22   | 22   | 19   | 21   | 21   | 23   | 22   | 23   | 23   |
| Чех       | 36   | 45   | 11   | 8    | 11   | 7    | 6    | 6    | 4    | 3    | 5    |
| БНСУ      | 8    | 36   | 53   | 23   | 17   | 3    | 5    | 5    | 10   | 8    | 20   |
| Турк      | 63   | 55   | 42   | 57   | 64   | 94   | 53   |      | 35   |      | 75   |
| Энэтхэг   | 30   | 30   | 30   | 30   | 30   | 30   | 50   | 40   | 40   | 40   |      |
| Казакстан | 3    | 1    | 3    | 5    | 4    | 5    | 5    | 2    | 8    | 15   | 6    |
| Куба      | 4    | 8    | 5    | 5    | 2    | 2    | 1    | 1    | 3    | 3    | 1    |
| Вьетнам   | 5    | 10   | 15   | 17   | 18   | 15   | 8    | 15   | 12   | 15   | 15   |
| Япон      | 103  | 86   | 87   | 100  | 88   | 58   | 58   | 58   | 35   |      | 58   |

*Эх сурвалж: БСШУЯ<sup>4</sup>*

Монгол Улсын оршин тогтнох, хөгжин дэвшихийн нэгэн язгуур хүчин зүйл бол гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх явдал юм. Тус сэдэвт Монгол, Оросын боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа, ОХУ-д сурч буй монгол оюутнууд болон Монголд сурч буй орос оюутнуудын тоо, тэтгэлгийн

Mongolica №1, Улаанбаатар, 2017 он, 63х.  
4 БСШУСЯ-ны сайт [www.mecs.gov.mn](http://www.mecs.gov.mn)

байдал зэрэгт анхаарал хандуулж, олон тулгуурт гадаад бодлого дахь боловсролын бодлогын хэрэгжилтэд өөрийн дүгнэлт өгөхийг зорьлоо.

Монгол-Оросын боловсролын салбарын хамтын ажиллагаа олон жилийн уламжлалтай. 1921 оны 11-р сарын 5-нд хоёр орны харилцааны түүхэн гэрээ хэлэлцээрийн эрх зүйн үндсийг тавьсан анхны баримт бичиг батлагдсан. Улмаар 1922 онд Москвагийн Дорно дахины хөдөлмөрчдийн коммунизмын их сургуульд (КУТВ) 15 хүн сургаснаас хойш Монгол-Оросын (хуучнаар ЗХУ) боловсролын харилцаа эрчимтэй хөгжиж, 1990 оныг хүртэл улс орны хөгжилд шаардлагатай 55 мянга гаруй мэргэжилтэн<sup>5</sup>, боловсон хүчин бэлтгэсэн түүхтэй. 1990-ээд оноос Монгол Улс нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж эхэлснээр улс төр, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг бүх салбарт гадаад харилцаагаа, түүний дотор ОХУ-тай тогтоосон уламжлалт харилцаагаа эрчимтэй хөгжүүлэхийг зорив.

Монгол, Оросын харилцааны стратегийн түншлэлийн түвшинг тодорхойлсон 1993, 2000, 2006, 2009 онуудын дөрвөн тулгуур баримт бичгүүдэд хоёр орны боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа тусгалаа олж, хууль эрх зүйн орчны нөхцлөөр баталгаажиж ирсэн. Тухайлбал: 1993 оны 1-р сарын 20-нд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол, Оросын хооронд байгуулсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” нь өнөөгийн харилцааны эрх зүйн шинэ үндэс болсон бөгөөд тус гэрээнд тусгасан зарчмуудыг хоёр талын сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөрдлөг болгож байна. Энэхүү гэрээний дагуу 1994 оноос Оросын Засгийн газрын тэтгэлэгээр монгол оюутанг сургаж эхэлсэн байна<sup>6</sup>. Үүний дараа Монгол Улс болон ОХУ-ын Засгийн Газар хоорондын 1995 оны 4-р сарын 5-ны өдөр Москва хотноо гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”<sup>7</sup> нь боловсролын салбарын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болж, талууд хэрэгцээ, боломжийн дагуу суралцах оюутанд

5 Пүрэвсамбуу, Г., Я.Индра., Монголия и Россия вечные соседи, Улаанбаатар, 2009, 200 с.

6 “Гадаад бодлогын үзэл баримтлал 20 жил”, [www.kas.de/wf/doc/kas\\_40579-1522-1-30.pdf](http://www.kas.de/wf/doc/kas_40579-1522-1-30.pdf)

7 “Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд 1991-2004”, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, Улаанбаатар, 2006 он, 99х

тэтгэлэг харилцан олгох, боловсролын байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтооход туслалцаа үзүүлэх, эрдмийн зэрэг цолыг харилцан хүлээн зөвшөөрөх, хоёр улсын хэлийг судлах ажлыг харилцан хөхиүлэн дэмжихээр тохиролцсоны дагуу хамтын ажиллагаагаа хөгжүүлэх болов.

2003 оны 6-р сарын 26-нд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2003-2006 онд хамтран ажиллах тухай гэрээ”<sup>8</sup>, “Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт гарын үсэг зурав. Эдгээр хэлэлцээр нь 2006 онд хоёр тал Москвагийн тунхаглалд гарын үсэг зурснаар баталгаажсан<sup>9</sup>. Энэхүү айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр “Монголын боловсон хүчнийг Оросын их, дээд сургуулиудад бэлтгэх нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааны хөгжилд зарчмын ач холбогдолтой” хэмээн цохон тэмдэглэсэн байна.

2006 оны 12-р сарын 8-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол-Оросын харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, “Москвагийн тунхаглал”-д гарын үсэг зурсан. Москвагийн тунхаглалд “Хоёр орны ард түмний оюун санааны болон соёлын ойр дотно уламжлалт хэлхээ холбоог хадгалан бэхжүүлэхийн төлөө байдаг. Монгол Улс, ОХУ нь ОХУ-ын их дээд, сургуульд суралцаж байгаа монгол оюутны тоог нэмэх, мэргэжилтэн бэлтгэх, давтан бэлтгэх, сургалтын хөтөлбөр солилцох замаар хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах болно. Монгол Улсад орос хэлийг, ОХУ-д монгол хэлийг сурах, судлахыг хөхиүлэн дэмжих болно” хэмээн тунхагласан.

2009 оны 8-р сарын 25-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Монгол Улсад айлчлах үеэр байгуулсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай Тунхаглал” юм.

---

8 Гадаад харилцааны төв архив. “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2003-2006 онд хамтран ажиллах хөтөлбөр” . <http://www.mfa-archives.mn/DataSearch/Default.asp>

9 “Боловсрол, шинжлэх ухааны салбарт одоо мөрдөгдөж буй хүчин төгөлдөр гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт”. БСШУСЯ-ны сайт, <http://www.meds.go.mn/> гэрээ хэлэлцээр

Хоёр орны харилцааны эрх зүйн үндэс болсон эдгээр тулгуур баримт бичиг нь Монгол, Оросын харилцаа цаашид урт хугацаанд тогтвортой урагшлан хөгжих хэтийн төлвийг нээж, боловсролын харилцаа, оюутан солилцооны гол баримт бичгүүд болсон.

Монгол Улсын Засгийн газрын гадаад бодлого дахь боловсролын салбарын нэг чухал зорилт нь ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх явдал юм. Монгол Улсын хувьд ОХУ-д оюутан сургах квот (ОХУ-ын Засгийн газрын холбооны төсвийн хөрөнгөөр суралцах оюутан)-ыг нэмэх асуудлыг Оросын талд байнга санал болгодог талаар ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны соёлын атташе Е.О.Чернышева ярилцлагаас харж болох юм. Тэрээр “Монголчуудын хувьд ОХУ-д суралцах сонирхол их байдаг. ОХУ-ын хувьд тэтгэлгээр суралцагчдын тоо, сар бүр олгодог амьжиргааны зардлыг нэмүүлэх саналаа Засгийн газартаа хандан байнга гаргадаг. Квотын тоог ОХУ-ын Засгийн газраас гаргадаг. Зөвхөн Монгол Улсаас төдийгүй гадны улсаас сургах оюутны тоог тогтоодог. Бид батлагдсан квотын дагуу асуудлыг шийддэг журамтай. Түүнчлэн квотын тодорхой хувийг их, дээд сургуулиудад олгох, сургуулиуд нь өөрсдөө оюутнаа сонгон авах, асуудлаа бие даан шийддэг болох асуудлыг тавьж байгаа”<sup>10</sup> хэмээн ярьсан байдаг. Энэ байдлыг Оросын Засгийн газар анхааран үзэж, Монголд олгох тэтгэлгээ нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч иржээ.

ОХУ-ын Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 891 тоот тогтоолын дагуу Оросын их дээд сургуулиудад ОХУ-ын Засгийн газрын холбооны төсвийн хөрөнгөөр Монгол Улсын иргэн, Монгол Улсад суугаа харьяалалгүй иргэд болон Монгол Улсад байнга оршин суугаа оросын эх орон нэгтнүүдийг 2015-2016 оны хичээлийн жилд боловсролын дараах программ, түвшиний дагуу элсүүлэхээр 350 хуваарь олгосон байна.<sup>11</sup>

2014 оны 9-р сарын 3-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газраас ОХУ-д сургах оюутны тоог мянгад хүргэх санал тавьсны дагуу ОХУ нь 2016 онд

10 “ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны соёлын атташе Е.О.Чернышевагийн ярилцлага”  
<http://ardiinerkh.mn/post/1097?date=93>

11 <http://www.mecss.gov.mn/data/1502/Russia2015.pdf>

Засгийн газрын тэтгэлгээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх, их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний төсөлт уралдаануудад хамтран оролцох, шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, орос-монгол хэлийг зайн сургалтын орчин үеийн технологи ашиглан хөгжүүлэх зэрэг чиглэлээр хэлэлцэн хоёр талаас цаашид анхааран ажиллах чиглэлийг тодорхойлов<sup>12</sup>. Эдгээр гэрээ хэлэлцээрийн дагуу 1994 оноос Оросын их, дээд сургуулиудад нэг жилд 30 оюутан сургаж эхэлж байсан бол 2016 он гэхэд энэ тоо 474 болж 16 дахин ихэссэнээр манай улсын боловсролын салбарын гадаад бодлого тодорхой хэмжээнд амжилттай хэрэгжиж байна.

Оросын боловсрол бол монголчууд аж үйлдвэрийн хувьсгалын дараах европын соёлтой танилцах анхны гүүр байсан. Ялангуяа социализмын үед Монгол дахь модернизацийн үйл явцын гол түлхүүр Зөвлөлтөд боловсрол эзэмшсэн монголчууд байв. Мөн түүнчлэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхай төсөөлөгдөж буй ажлын байрны тоо нь мэргэжилтэй Монгол боловсон хүчний нөөцөөс даваад байна. Энэ байдал ялангуяа инженер, технологийн салбарт хүчтэй мэдрэгдэж байгаа юм. Монголын эдийн засгийн хөгжилд, ялангуяа өндөр зэрэглэлийн мэргэжлийн болон бизнесийн удирдлагын албан тушаалд гадаадын ажилчид давамгайлах хандлагатай байна. Ийм нөхцөлд ОХУ-ын Засгийн газраас Монголын талд олгодог тэтгэлгийг үр дүнтэй ашиглах, нэн эрэлт хэрэгцээтэй байгаа уул уурхай, шинжлэх ухаан, дэд бүтэц, ургамал, байгаль орчин хамгаалал, мал эмнэлэг, нарийн мэргэжлийн инженер, техник, технологийн салбаруудад мэргэжлийн чадварлаг боловсон хүчин бэлтгэх, боловсролын байгууллага хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, бодит үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллах нь хоёр орны стратегийн түншлэлийн харилцааны хэтийн төлөвийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

---

12 <http://www.mongolia.mid.ru/mn/eco-inf.html>

### Гадаадад сурч буй монгол оюутны тоог Оросод сурч буй оюутны тоотой харьцуулах нь

Хэдийгээр хоёр орны ЗГ-ын хэлэлцээрийн дагуу ОХУ-д олон оюутан тэтгэлэгээр сурч байгаа тоо байгаа боловч 2015 онд Гадаад харилцааны яамнаас гадаадад ямар нэгэн тэтгэлгээр болон хувиараа суралцаж буй нийт монгол оюутны албан бус тоог судлахад дараах үр дүн гарчээ.

#### 2015 оны байдлаар гадаадад суралцаж буй

##### Монгол оюутнуудын тоо

| №  | Улсын нэрс     | 18-аас доош нас | 18-аас дээш нас | Нийт тоо    |
|----|----------------|-----------------|-----------------|-------------|
| 1  | Хятад          | 415             | 7924            | 8339        |
| 2  | Солонгос       | 2902            | 5061            | 7963        |
| 3  | Япон           | 1185            | 5405            | 6590        |
| 4  | Канад          | 960             | 1570            | 2530        |
| 5  | <b>Орос</b>    | <b>112</b>      | <b>1824</b>     | <b>1936</b> |
| 6  | Герман         | 742             | 950             | 1692        |
| 7  | Англи          | 634             | 900             | 1534        |
| 8  | Чех            | 1300            | 86              | 1386        |
| 9  | Казакстан      | 148             | 743             | 891         |
| 10 | Бусад улс орон | 310             | 3961            | 4271        |

*Эх сурвалж: Монголын мэдээ сонин<sup>13</sup>*

Дээрх хүснэгтээс харахад хувиараа болон тэтгэлгээр суралцаж буй нийт монгол оюутны тоогоор БНХАУ нь ОХУ-аас дөрөв дахин олон бөгөөд бодит байдал дээр Монголчууд Хятад, Япон, Солонгос зэрэг улсад суралцах сонирхол их байна. Монгол Улсын Засгийн газраас эн тэргүүнд ОХУ-тай боловсролын харилцаагаа хөгжүүлэх бодлогын хэрэгжилт бодит байдал дээр тун хангалтгүй байгааг тус тоо баримт харуулж байна. Үүнд дараах шалтгаануудыг тоочиж болох юм. Нэгт, Орост сурч буй монгол оюутнууд үндсэндээ ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцагчдаас бүрдэж, харин мужийн, сургуулийн болон бусад төрлийн тэтгэлгээр суралцагчид маш цөөхөн байна.

13 МОНЦАМЭ мэдээ сонин хятад хэл дээрх, 2016.10.3-ийн мэдээ

Өөрөөр хэлбэл, монголчуудын дунд өөрийн сонирхлоор ОХУ-д сонгон суралцах явдал цөөн бөгөөд Орост суралцахаар явахад тус хоёр улсын Засгийн газрын дэмжлэг гол хүчин зүйл болж байна. Харин Хятад, Япон, Солонгос, Америк зэрэг улсад суралцаж буй монгол оюутнуудын дунд мужийн, сургуулийн зэрэг Засгийн газрын бус тэтгэлэг болон хувиараа суралцах явдал давамгайлж байгаа бөгөөд гол хүчин зүйл нь тухайн улсад очиж суралцах гэсэн суралцагчийн өөрийн санаачилга байна.

Хоёрт, Дээрх байдал нь эн тэргүүн тэтгэлгийн хэмжээ ба амьжиргааны өртөгтэй холбоотой юм. ОХУ-ын томоохон сургуулиуд байрладаг гол хотууд нь дэлхийн хамгийн өндөр өртөгтэй хотуудын тоонд ордог бөгөөд 2012 оны байдлаар ОХУ-д тэтгэлгээр сурч байгаа монгол оюутны амьжиргааны тэтгэлэгт сард 900 рубль (16 америк доллар), докторантад 1750 рублийн<sup>14</sup>(31 америк доллар) стипендийг сургалтын төлбөрийн хамт олгож байгаа нь ойролцоо өртөгтэй бусад улсын дундаж тэтгэлгээс 10-20 дахин бага байна. Үүнтэй харьцуулахад Хятадын Засгийн газрын тэтгэлэг магистрантад 3000 юань (435 америк доллар), докторантад 3500 юань (508 америк доллар), Япон, Солонгосын дундаж тэтгэлэг дунджаар 500 америк доллар байна. Үүний хамт ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцагч нь замын зардал, эрүүл мэндийн даатгал, дотуур байрны болон хоол ундны зардал, виз, эрүүл мэндийн шинжилгээ гэх мэт зардлуудыг өөрөө хариуцдаг бол<sup>15</sup> Япон, БНСУ зэрэг зарим нэг орнуудад Засгийн газрын ба Засгийн газрын бус тэтгэлгээр сурахад сургалтын төлбөрөөс гадна бусад ихэнх зардлууд тэтгэлэгт багтдаг. Орост сурахтай холбогдсон эдгээр санхүүгийн нөхцөл байдлаас болж монгол залуус БНХАУ, Япон, БНСУ болон амьжиргааны тэтгэлэг өндөртэй бусад улсуудад олноор суралцахад хүргэж байна. Гуравт, Монгол оюутнууд Орост суралцахад сөргөөр нөлөөлж буй бас нэг хүчин зүйл бол Оросоос өөр төрхтэй хүмүүсийн аюулгүй байдлын асуудал юм. ЗХУ задарсны дараа бий болсон улс төр, эдийн засгийн хүнд байдлаа орос биш үндэстнүүдтэй

14 <http://mn.russia.edu.ru/enter/quot>Гадаадын иргэд болон гадаадад амьдарч байгаа нутаг нэгтгүүдийн сургалттай холбоотой зардал, тэдний тэтгэлэг зэргийг элсэн төрийн өмчийн их дээд сургууль, академийг харьяалж буй яам болон төрийн байгууллагаас хариуцна. Харин санхүүжилтийн хэмжээ нь тухайн санхүүжилтийн жилд (төлөвлөгөөг хугацаанд) боловсролд зориулж төлөвлөж холбооны улсын төсөвт тухайн яам, төрийн байгууллагаас тусгасан хөрөнгийн хэмжээгээр тодорхойлогдоно.  
15 БСНУСЯ-ны сайт, <http://www.mecss.gov.mn/data/1502/Russia2015.pdf>

холбон тайлбарладаг хүчин Орост бий болсон нь нацист бүлэглэл болох халзан толгойтнууд буюу скинхэдүүд юм. 1990 оноос хойш Оросын шинэ нацистууд монголжуу төрхтэй гадаадын иргэд, түүний дотор монгол иргэдийн эрх чөлөөнд халдах явдал олонтаа давтагдаж, үүний улмаас Монголын олон нийтийн дунд Орост суралцах, аялахаас болгоомжлох хандлагыг бий болгоод байна. Үүний хамт Монгол Улсын Засгийн газраас ОХУ-д суралцаж, ажиллаж буй иргэнийхээ аюулгүй байдал, амьжиргааны асуудлыг тэр бүр хөнддөггүй ба ОХУ-д сурч байгаа оюутнуудтайгаа ОХУ дахь Монгол Улсын Элчин сайдын Яам нь харилцаа муутай ажилладаг, Москва, Улаан-Үд, Эрхүү хотуудаас бусад том хотуудад Консулын газар байхгүйгээс эрх нь зөрчигдсөн Монгол Улсын иргэнд дэмжлэг үзүүлж чаддаггүй<sup>16</sup> зэрэг нөхцөл байдал нь монгол залуус ОХУ-д сурахаар одох явдалд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын Засгийн Газар, Оросын талд олон оюутан сургах хүсэлтийг байнга тавьж, ОХУ-ын Засгийн газраас ч энэ талаар анхаарч үзэн тэтгэлгээр сургах монгол оюутны тоог нэмэгдүүлж ирсэн боловч Монгол дахь гадаадад боловсрол эзэмшсэн боловсон хүчний дотор ОХУ-д боловсрол эзэмшсэн боловсон хүчин эрс цөөрөх нөхцөл байдал нэгэнт бий болжээ.

Орос хэл нь Европт хамгийн өргөн тархсан хэл бөгөөд дэлхийн 260 сая хүн орос хэлээр ярьдаг. Энэ тоогоороо дэлхийд 8-д орж байна. ОХУ нь боловсролын баримт бичиг хүлээн зөвшөөрөллөх талаар олон улстай олон тооны гэрээ байгуулсан бөгөөд Оросын байгаль шинжлэл, инженерийн боловсрол нь дэлхийд шилдэгт тооцогддог байна. Мөн Орос улс нь математик, хими, геологи, эмч зэрэг бусад салбарт мэргэжилтэн бэлтгэхдээ дэлхийд тэргүүлэх байр эзэлдэг. Оросын их дээд сургуулиуд дэлхийн тэргүүлэх их сургуулиудтай байнгын хамтын ажиллагаатай байдаг бөгөөд Оросын их сургуулийг байгалийн шинжлэл, инженерийн мэргэжлээр төгссөн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ гадаад орнуудад их байдаг байна.

ОХУ-ын Засгийн газар боловсролын салбарын стратегийн гол зорилгоо мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийн шаардлага, иргэн ба нийгмийн орчин үеийн хэрэгцээнд нийцсэн чанартай боловсролын

16 Нямдолжин.А., “Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны салбар дахь Монгол улс, ОХУ-ын хамтын ажиллагаа”, Олон улс судлал, Улаанбаатар, 2010, №1,2, 70х.

хүртээмжийг дээшлүүлэх явдал<sup>17</sup> хэмээн тодорхойлжээ. Сүүлийн жилүүдэд ОХУ нь орос хэлийг бусад улс орнуудад сургалчлах, орос хэлний багш нарыг бэлтгэх, дадлага хийлгэх, зуны сургалтанд хамруулах, онлайн сургалт зохион байгуулах, орос хэл, соёл, уламжлалыг бусад улс оронд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Тухайлбал, ОХУ-ын их дээд сургуульд жил бүр гадаадын 150 орны 270 мянган оюутан элсэн сурч байгаагийн дотор 15 мянган оюутанд Оросын төсвийн хөрөнгөөр тэтгэлэг олгон суралцуулж байна. Эдгээрийн дотор Монгол оюутнууд Хятад, Вьетнамын дараа дээгүүр ордог бөгөөд өнөөгийн байдлаар Оросын 26 хотын 109 их дээд сургуульд ойролцоогоор 2000 монгол оюутан сурч байна.

### **Монгол дахь Орос оюутан**

Монгол-Оросын боловсролын харилцааны өөр нэг чухал тал бол Монголд орос оюутнууд суралцах явдал юм. Монгол Улсад гадаад оюутан олноор суралцах нь Монгол улсын нэр хүнд өсөх, аялал жуулчлал хөгжих, хөрөнгө оруулалт нэмэгдэх гэх мэт маш олон давуу талыг дурдаж болно. 1950 оноос МУИС-ийн Монгол хэлний ангид гадаад оюутан суралцаж эхэлсэн бөгөөд 1990-ээд оноос Монгол Улсын гадаад харилцаа шинэ шатанд дэвшиж, олон улстай найрсаг харилцаатай болсноор Монголд суралцах гадаад оюутны тоо эрс нэмэгдэв. Монгол Улс гадаадын оюутнуудад бусад улсуудын адил тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх эдийн засгийн нөөц бололцоо хомс хэдий ч манай улсад суралцаж буй гадаад оюутаны тоо 2002 оноос хойш хурдацтай нэмэгдэж байна. Сүүлийн 10 жилийн байдлын ажилвал.

### **Гадаадаас Монгол Улсад суралцагчдын статистик тоо**

|                      | 2007  | 2008  | 2009 | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016 |
|----------------------|-------|-------|------|-------|-------|-------|-------|-------|-------|------|
| Улсын тоо            | 28    | 26    | 22   | 31    | 29    | 32    | 30    | 32    | 27    | 32   |
| Гадаадын суралцагчид | 1,207 | 1,106 | 996  | 1,039 | 1,058 | 1,098 | 1,130 | 1,245 | 1,450 | 1520 |

<sup>17</sup> Нямдолжин.А., “ОХУ-ын Боловсролын хөгжлийн тэргүүлэх зорилт, стратеги”, Олон улс судлал, Улаанбаатар, 2012, №2.

|                    |     |     |     |     |     |     |     |       |       |     |
|--------------------|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-------|-------|-----|
| Үүнээс:<br>эмэгтэй | 543 | 553 | 474 | 471 | 464 | 504 | 513 | 594   | 704   |     |
| Хэлний бэлтгэлд    | 99  | 108 | 68  | -   | -   | -   | -   | 112   | 99    | 850 |
| Бакалавр           | 952 | 800 | 728 | 837 | 830 | 796 | 818 | 761   | 845   | 850 |
| Магистр            | 132 | 171 | 153 | 145 | 167 | 204 | 209 | 258   | 368   | 497 |
| Доктор             | 24  | 27  | 47  | 57  | 61  | 98  | 103 | 114   | 138   | 173 |
| МУ-ын зардлаар     | 148 | 27  | 99  | 151 | 135 | 146 | 124 | 126   | 102   | 104 |
| Хувийн             | 958 | 875 | 805 | 847 | 860 | 820 | 843 | 1,004 | 1,207 | 121 |
| Байгууллагын       | 78  | 70  | 74  | 31  | 45  | 105 | 75  | 46    | 70    | -   |
| Тухайн улсын       | 22  | 124 | 18  | 10  | 17  | 21  | 22  | 20    | 33    | -   |
| бусад зардлаар     | 1   | 10  | -   | -   | 1   | 6   | 66  | 49    | 38    | 155 |

Эх сурвалж: БСШУСЯ<sup>18</sup>

2015 оны хичээлийн жилд Монголд суралцах гадаад иргэдийн тоо 70-аар буюу 4.6 хувиар өссөний дотор магистрантурт суралцагчдын тоо 129-өөр, докторантурт суралцагчдын тоо 35-аар тус тус нэмэгдсэн бол бакалавраар суралцагчдын тоо 94-өөр буурсан байна.<sup>19</sup>Сүүлийн 5 жилд Монгол Улсад гадаадаас суралцагчдын тоо өсөж байгаагийн дотор магистрантур, докторантурт суралцагчдын тоо нэмэгдэх хандлагатай байна.

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар Монгол Улсад суралцаж буй ОХУ-ын оюутан, сурагчид МУИС, ЭМШУИС, ШУТИС, СУИС, ХААИС, МҮИС, Аварага ДС, Бурхан шашны ДС (Буриад Тува оюутан) зэрэг сургуулиудад сурч байгаа бол дийлэнх хувь нь Г.В.Плехановын нэрэмжит Оросын Эдийн засгийн их сургууль, ОХУ-ын Дорнод Сибирийн Технологи, удирдлагын ИС-ийн УБ дахь салбар

<sup>18</sup> Пүрэвжал.А, БСШУСЯ-ны Инноваци, өндөр технологийн газар, БСШУСЯ-ны албан хэрэгцээнд

<sup>19</sup> Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн танилцуулга. <http://www.mecss.gov.mn/data/1702/HigherSta1617ab>

сургуулиудад сурч байна. Монголд суралцаж буй хоёр хөрш орны суралцагчдын тоог харьцуулан үзвэл.

Хүснэгт 5



Эх сурвалж: БСШУСЯ<sup>20</sup>

Сүүлийн нэг жилийн дотор Монгол дахь ОХУ-ын суралцагчид 24-өөр багассан бол БНХАУ-ын суралцагчид 132-оор нэмэгджээ.<sup>21</sup> Ялангуяа БНХАУ-аас суралцагчдын тоо сүүлийн 5 жилд 2.7 дахин нэмэгдэж, харин ОХУ-ын суралцагчдын тоо 2005 оноос хойш тасралтгүй буурчээ. Хөрш орон болох ОХУ-ын суралцагчид бага байгаа шалтгааныг тодруулах үүднээс Монголд суралцсан орос оюутны тоо болон боловсролын байдлаар нь 2005-2015 оныг хүртэлх 10 жилийн хугацаагаар тодорхойлон гаргавал:

Монгол Улсад 2005-2015 оны хооронд суралцсан ОХУ-ын оюутан, сурагчдын судалгаа

| Он   | Нийт | Үүнээс эм | Боловсролын зэрэг |     |    |   | Сургалтын зардал |          |             |              |       |
|------|------|-----------|-------------------|-----|----|---|------------------|----------|-------------|--------------|-------|
|      |      |           | Хэлний бэлтгэл    | D   | E  | F | Монгол улсын     | Хувиараа | Байгууллага | Тухайн улсын | Бусад |
| 2005 | 623  | 323       | 27                | 514 | 80 | 2 | 4                | 568      | 1           | 23           | 27    |
| 2006 | 553  | 286       | 11                | 486 | 20 | 2 | 83               | 413      | 2           | 21           | 0     |

20 Пүрэвжал.А, БШУЯ-ны Инноваци, өндөр технологийн газар, БСШУСЯ-ны албан хэрэгцээнд

21 <http://www.mecss.gov.mn/data/1702/HigherSta1617ab>

|      |     |     |    |     |    |   |    |     |    |    |    |
|------|-----|-----|----|-----|----|---|----|-----|----|----|----|
| 2007 | 454 | 252 | 12 | 438 | 2  | 2 | 8  | 367 | 0  | 79 | 0  |
| 2008 | 454 | 252 | 12 | 438 | 2  | 2 | 8  | 367 | 0  | 79 | 0  |
| 2009 | 411 | 212 | 5  | 396 | 8  | 2 | 54 | 329 | 13 | 15 | 0  |
| 2010 | 395 | 219 | -  | 389 | 3  | 3 | 59 | 322 | 4  | 10 | 0  |
| 2011 | 372 | 177 | -  | 363 | 6  | 3 | 56 | 298 | 10 | 7  | 1  |
| 2012 | 287 | 148 | -  | 258 | 25 | 4 | 44 | 227 | 4  | 9  | 3  |
| 2013 | 250 | 118 | -  | 240 | 7  | 3 | 25 | 206 | 6  | 3  | 10 |
| 2014 | 254 | 140 | 7  | 235 | 8  | 4 | 27 | 211 | 2  | 2  | 12 |
| 2015 | 206 | 97  | 4  | 195 | 5  | 2 | 20 | 168 | 3  | 3  | 12 |

Эх сурвалж:<sup>22</sup> БСШУСЯ

Дээрх хүснэгтээс үзэхэд сүүлийн арван жилд ОХУ-аас Монгол Улсад 2005 онд 623 оюутан сурч байсан бол 2015 он гэхэд 168 оюутан болтлоо буурсан байна. Тэдний ихэнх нь Монголд хувийн зардлаар суралцаж байна. ОХУ-ын оюутан, суралцагчдын тоо жил ирэх тусам багасаж байгаа нь Монголын талаас олгох тэтгэлэг бага бөгөөд суралцагчид хувийн зардлаар суралцдагтай холбоотой байж болох юм. Үүний дотор боловсролын зэргийн хувьд 90 хувь нь докторын зэрэг хамгаалахаар суралцаж, харин бакалаварын зэрэг хамгаалах хүсэлтэй оюутан цөөрч байгаа нь харагдаж байна. Иймээс манай улс гадаадын оюутанг олноор сургах асуудлыг шийдэхийн тулд юуны түрүүнд гадаад оюутанд тулгардаг бэрхшээлийг судалж тогтоох, даван туулах арга замыг нь зааж өгөх, зөвөлгөө, гарын авлага гаргах нь чухал юм.

### **Монгол дахь ОХУ-ын боловсролын байгууллагууд**

Монголд Оросын дээд сургуулийн салбар байгуулагдан ажиллаж эхэлсэн нь хоёр улсын хамтын ажиллагааны түүхэнд шинэ үйл явдал юм. Монгол Улс, ОХУ-ын их, дээд сургуулиудын хоорондын хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаагийн дээр манай улсад Оросын их, дээд сургуулиудын салбарууд байгуулагдан ажиллаж эхэлсэн нь хамтын ажиллагааны түүхэн дэх шинэ хэлбэр юм. Өнөөгийн байдлаар Плехановын нэрэмжит Эдийн засгийн Академи, Дорнод Сибирийн Технологи, удирдлагын их сургууль, Эрхүүгийн Зам харилцааны улсын

<sup>22</sup> Пүрэвжал.А, БШУЯ-ны Инноваци, өндөр технологийн газар, БСШУСЯ-ны албан хэрэгцээнд

их сургуулийн Улаанбаатар дахь салбар сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж, манай боловсролын тогтолцоонд байр сууриа эзлэн тодорхой хувь нэмэр оруулж байна. Эдгээр сургуулиудад ОХУ-ын суралцагчид жил болгон олон тоогоороо ирж суралцдаг. Өдгөө Улаанбаатар хотод Москвагийн Эрчим хүчний их сургууль, Багшийн их сургууль, Плехановын нэрэмжит Буриад, Кемеровын улсын их сургуулиудын салбарууд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийслэл, бусад хот суурин газруудад цөөнгүй тоогоор байгуулагдсан орос хэл дээр сургалттай бага, дунд сургууль, цэцэрлэгүүд үйл ажиллагаа явуулж эхэлжээ.

БСШУ-ны сайд Ж.Батсуурь 2016 оны 11-р сарын 28-нд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд МУБИС-д Орос хэлний сургалтын төвийг ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Их Сургуулийн дэмжлэгээр байгуулахаар болсон. Түүнчлэн 2017-2018 оны хичээлийн жилд орос хэлний бэлтгэл анги нээж хичээллүүлэх бөгөөд ингэснээр дараагийн жилүүдэд ОХУ-д суралцах залуусыг нэг жилийн бэлтгэл курст суралцуулаад, тус улсын тэтгэлэгт хамруулах боломж бүрдэж байгаа мэдээлэл байна.

Монгол Улсад оросын боловсролын байгууллагууд олширч, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нь Монголын боловсролын хөгжилд чухал дэвшил үзүүлэхээс гадна Монгол залуус ОХУ-д суралцах хүсэлтэй болоход нөлөөлөх юм.

### ***ДҮГНЭЛТ***

Монгол-Оросын боловсролын салбарын хамтын ажиллагаа олон жилийн уламжлалтай ба Монгол Улсын хувьд Зөвлөлт Оростой тогтоосон боловсролын харилцаа нь XX зууны хамгийн чухал ололтуудын нэг байсан бөгөөд өнөөдрийг хүртэл монголын ард түмэн оросын боловсролын систем, шинжлэх ухааныг өндөрөөр үнэлсээр байгаа юм. 1990 оноос хойш хоёр орны Засгийн газрын боловсролын салбарт хийгдэж буй гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын зүгээс монгол оюутан залууст олгох тэтгэлэгийн тоог жилээс жилд нэмэгдүүлж ирсэн боловч монголчууд Хятад, Япон, Солонгос зэрэг орнуудад суралцах сонирхол их байна. Иймээс Монгол Улсын Засгийн газар нээлттэй,

олон тулгуурт гадаад бодлогын боловсролын харилцаа, хамтын ажиллагаагаа өнөөгийн нөхцөл байдалд тохирсон тодорхой хэмжээний бодлого гаргаж, ОХУ-тай тогтоосон боловсролын харилцааг тусгайлан авч үзэж, үүнд зориулж Монголын талаас тусгайлан хөрөнгө мөнгө гаргаж ОХУ-д суралцагчдыг санхүүгийн талаар дэмжих, Монгол дахь оросын боловсролын байгууллагуудыг хөрөнгө санхүү, боловсон хүчин, бусад шаардлагатай зүйлсээр дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

### ***АШИГЛАСАН МАТЕРИАЛ***

1. “Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд 1991-2004”, УБ,2006 он
2. Төмөр-Очир С., “Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны салбар дахь Монгол Улс, ОХУ-ын хамтын ажиллагаа”, Олон улс сэтгүүл 2007№3, УБ, 2007он
3. Нямдолжин.А, “ОХУ-ын Боловсролын хөгжлийн тэргүүлэх зорилт, стратеги”. “Олон улс судлал” сэтгүүл, УБ, 2012,№2
4. Нямдолжин.А, “Монгол, Оросын боловсролын салбарын хамтын ажиллагаа, хэтийн төлөв” ЭШХурал. Төрийн ордонд. 2017.02 сар
5. Сайхансанаа, Д.Даш, “Хүйтэн дайны дараахи Монгол Улсын гадаад харилцааны бодлого ба “олон тулгуурт” гадаад харилцааны бодлого” <http://mongoliajol.info/index.php/JIS/article/view/389>
6. Гадаад Харилцааны Яам.2011. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”. [http://www.mfa.gov.mn/index.php?option=com\\_content&view](http://www.mfa.gov.mn/index.php?option=com_content&view)
7. “Гадаад бодлогын үзэл баримтлал 20 жил” УБ, 2014 он. <http://www.kas.de/wf/doc/kas>
8. БСШУСЯ-ны сайт [www.mecss.gov.mn](http://www.mecss.gov.mn)
9. Статистикийн мэдээлэлийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn),
10. Монгол Банк “Монгол Улсад суралцагч гадаад оюутны зардлын судалгааны тайлан” [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn),

11. ОХУ-ын Боловсрол, Шинжлэх ухааны яамны сайт <http://mn.russia.edu.ru/enter/why/>
12. Бүдсүрэн.Д., “Монгол-АНУ-ын боловсролын салбарын хамтын ажиллагаанд олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг: Фулбрайт болон Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөрийн жишээн дээр”, Фах Mongolica №1, Улаанбаатар, 2017 он, 63х